



МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Ур чадварын нэмэгдэл олгох ажлын хэсгийг
шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ыг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний ажлын хэсгийг шинэчлэн томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Захиалагч менежер /Я.Болдбаатар/

Гишүүд

Ахлах нягтлан бодогч /Н.Туяа/
Спорт, аялал жуулчлал хариуцсан
мэргэжилтэн /Д.Өлзийсайхан/
Ашиглалтын инженер /Т.Эрдэнэбат/
Хүний нөөц, дотоод асуудал хариуцсан
мэргэжилтэн /Б.Дашдорж/

Нарийн бичгийн дарга

2. Ур чадварын нэмэгдлийг сар бүр дүгнэх ажлыг зохион байгуулахыг Хүний нөөц, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн /Б.Дашдорж/-д даалгасугай.

3. Нийт албан хаагчдын ур чадвар олгох жагсаалтын дагуу нэмэгдлийг ажилтны үндсэн цалингийн 25 хувиас хэтрүүлэхгүй байхаар тооцож, холбогдох журмын дагуу бодож олгохыг Ахлах нягтлан бодогч /Н.Туяа/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиалагч менежер /Я.Болдбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.БАТСҮМБЭРЭЛ

215030537



МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Орон тооны бус зөвлөл байгуулах ажлын
хэсэг томилох тухай

Байгууллагын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалт, Дотоод журмын 2 дугаар хэсгийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дэргэдэх “Орон тооны бус бодлогын зөвлөл”-ийг байгуулан, ажиллах журмыг боловсруулах, уулзалт хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга

Захиалагч менежер /Я.Болдбаатар/

Гишүүд

Соёл, урлаг хариуцсан мэргэжилтэн /Б.Солонго/
Хуулийн мэргэжилтэн /О.Уянга/
Мастер /С.Энхбаатар/
Гадаад харилцаа, хамтын ажиллагааны
мэргэжилтэн /Б.Баяр/

Нарийн бичгийн
дарга

Спорт, аялал жуулчлал хариуцсан
мэргэжилтэн /Д.Өлзийсайхан/

2. Бодлогын зөвлөлийн ажиллах журмыг боловсруулах, уулзалт хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах ажлыг 2016 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн дотор багтаан зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Я.Болдбаатар/-д даалгасугай.

3. Батлагдсан зардлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хавсралтад заагдсан үйл ажиллагаанд зарцуулахыг байгууллагын ахлах нягтлан бодогч /Н.Туяа/-д зоршоосүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн дарга /Я.Болдбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.БАГСҮМБЭРЭЛ

215030269